

МОНГОЛ-GERМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ (МГТИС) III



ГАРААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монголын их дээд сургуулиуд оюутнуудыг ирээдүйн мэргэжилд нь бэлтгэхдээ учир дутагдалтай байна. Тиймээс ажил олгогчдын хайж буй практик мэдлэг, хэрэглээний ур чадвар төгсөгчдөд дутмаг байдаг.

2016 оны тогтвортой байдлын зорилтуудыг хэрэгжүүлэх үндэсний стратеги нь олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай боловсролыг их дээд сургуулиудад бий болгохыг зорьдог. Үүний тулд сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа нь бие биенээ нөхөж, бэхжүүлдэг байх шаардлагатай.

Цаашилбал, Монголын Засгийн газар нь багшлах, судалгаа хийх, үйлдвэрүүдтэй хамтран ажиллах явдлыг илүү бодитой болгох үүднээс 2012 оноос эхлэн академик болон байгууллагын шинэчлэлийг эхлүүлсэн.

Төслийн нэр	Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) III
Захиалагч	ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)
Төсөл хэрэгжих бүс нутаг	Улаанбаатар болон Налайх дахь их сургуулийн хотхон
Хамтран хэрэгжүүлэгч	Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)
Хугацаа	07/2019 – 06/2022 (2020 оны 11-р сард болсон Монгол-Германы засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд төслийг 2022 оны 7-р сарын 1-ээс 2023 оны 12-р сарын 31 хүртэл сунгахаар тохиролцсон)



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГА БАРИЛ

Төсөл нь МГТИС-ийн практикт чиглэсэн сургалтуудыг дэмжиж, их сургуулийн бүтэц, чанарын менежмент, заах арга зүйн мэргэшлийн талаар зөвлөгөө өгдөг. Үүгээрээ их сургуулийг Монголын боловсролын орчинд өөрийгөө бататгаж, судалгаа, сургалтын чиглэлд үйлчлэх хүрээг нь өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Энэхүү төсөл нь санхүүгийн хувьд ашигтай бизнесийн загвар нэвтрүүлэхэд нь МГТИС-г дэмждэг. Үүний сацугаар шинэ сургалт явуулахын тулд сургалт, кампусын менежмент, МГТИС-ийн чанарын системийг цаашид хөгжүүлэх юм. Төсөл нь ялангуяа бага орлоготой иргэдэд их сургуульд суралцах боломжийг бүрдүүлэх зорилготой.

МГТИС-д дигиталчлалыг дэмжихийн тулд төсөл нь Хэрэглээний мэдээллийн технологийн Фраунхофер институт, Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран ажиллаж байна. Дигитал платформыг хэрэгжүүлснээр их дээд сургууль төгссөн гэрчилгээний жинхэнэ эсэхийг шалгах боломжтой юм.



ЗОРИЛГО

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх.



Төгсөгчид



Химийн лабораторийн хичээл дээр



МГТИС-ийн кампус хотхонд



ҮР НӨЛӨӨ

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь монголын ашигт малтмалын салбар, түүнд холбогдох үйлдвэрлэлд бий болоод буй өндөр мэргэшлийн инженер, технологийн шинжээчдийн орон зайг нөхөхөд дөхөм болох юм. МГТИС нь германы түншлэгч дээд сургуулиудтай анхнаасаа хэрэгжүүлж ирсэн хамтын ажиллагаандаа тулгуурлан олон улсын шинжлэх ухааны туршлага, орчин үеийн академик стандартыг Монголд нэвтрүүлж байгаа билээ. Мөн нэгэн зэрэг уг сургууль нь дадлагад чиглэсэн инженерийн сургалтаараа боловсролын салбар болон эдийн засгийг хооронд нь илүү холбох нөхцөлийг бүрдүүлдэг. Үүгээрээ уг сургууль монголын ашигт малтмалын салбар дахь боловсон хүчний эрэлт хэрэгцээг хангах, үнэ цэнийг нь өсөн нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд өөрийн хувь нэмрийг оруулдаг билээ. Түүнчлэн зохион байгуулалтынхаа хувьд ч МГТИС нь монголын дээд сургуулийн тогтолцоонд үлгэр жишээ болохуйц байж, удирдлагын бүтцээ орчин үеийн дээд сургуулийн менежментийн зарчимд нийцүүлэн, байгууллагын бие даасан байдлыг ханган ажилладаг. МГТИС нь инженер болон техникийн мэргэжилтнүүдэд зориулсан хэрэглээний шинжтэй судалгааг хөгжүүлж, мэргэжилд түшиглэсэн академик давтан сургалтаараа дунд хугацаанд монголын ашигт малтмалын салбар дахь аж ахуйн нэгжүүдийн хувьд түншлэгч нь болох боломжтой. Дээд сургуулийг хэрэглээнд ойртуулах германы Мэргэжлийн дээд сургуулийн загварт суурилсан МГТИС-ийн жишиг болон чанарын менежмент нь Монгол Улс дахь дээд сургуулиудын хувьд эерэг нөлөөтэй байх юм. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам нь дээд сургуулиудыг наад захын шаардлага хангуулахын тулд төрөөс аттестатчилах шаардлагатай байгаагаа мэдэгдсэн билээ. Монгол Улсын эдийн засгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн судалгааны бүтээлүүд цаашид гагцхүү үр нөлөө бүхий чанарын менежменттэй дээд сургуулиудаас төрөх магадлалтай.



МГТИС-ийн номын санд



Төсөл дээр ажиллаж буй оюутнууд

Нийтэлсэн: Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)
ХБНГУ-ын Бонн, Эшборн хотуудад оффистой

Холбоо барих: Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) III
Найман зовхис оффис, Сөүлийн гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14251
Утас +976 (11) 313030
И-Мэйл frank.wullkopf@giz.de
<https://www.giz.de/en/worldwide/23147.html>

Төслийн удирдагч: Др. Франк Вулкопф
Он, сар: 2021 оны 10-р сар
Хэвлэсэн: Эдмаркет ХХК, Улаанбаатар хот
Загварыг: Монгол дахь GIZ, Улаанбаатар хот



Нийтлэлийн агуулгыг Монгол дахь GIZ хариуцна.

Хамтран хэрэгжүүлэгч: Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам



Гэрэл зургийг: Зурагчин Бат-Эрдэнэ Намжилсүрэн

Захиалагч: ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)

Хаяг: BMZ Bonn
Postfach 12 03 22
53045 Bonn
T +02 28 / 9 95 35-0
F +02 28 / 99 10 53 5-35 00
BMZ Berlin
Stresemannstraße 94
10963 Berlin
T +030 / 1 85 35-0
F +030 / 1 85 35-25 01